

**“ШОХОЙ ЦАГААН БУЛАГ ХХК” –ИЙН
ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
“ШОХОЙТ УУЛ ОРД” 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-000919

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:2025833

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

Ц.Жаргалнэмэх

БОАЖЯ-ны харьяа,

Төв аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн

С.Эрдэнэцогт

Биелэлтийг тайлагнасан:

Шохой цагаан булаг ХХК-ийн Гүйцэтгэх захирал

/Б.Саруул/

Мэргэжилтэн

/Б.Энхбат/

2022 он

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН “ШОХОЙТ УУЛ” ОРДОД MV- 0919A ТООТ ЛИЦЕНЗТЭЙ ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү тайланг “Ашид Ананда” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн БОНБНУ-ний тайланд үндэслэн БОНХЯ-ын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаал иргэн, аж ахуйн нэгж тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн боловсруулав.

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Шохойт уул”-ын шохойн чулууны уурхай

Төслийн зорилго: Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн "Шохойт уул" гэдэг газарт өмнөх үед ашиглаж байсан шохойн чулууны ордыг үргэлжлүүлэн ашиглах төслийг хэрэгжүүлснээр орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгоход хувь нэмэр оруулах, байгалийн баялгийг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар олборлоно.

Төсөл хэрэгжүүлэгч: "Шохой цагаан булаг" ХХК. Регистрийн дугаар: 2025833
Улсын бүртгэлийн дугаар: 2911001065 Захирал: Ж.Батбаяр
Налайх дүүргийн 5-р хороо, Их булгийн, Шохой цагаан булаг-
Шохойн хэсэг. Утас: 99115635, 88116981, 88007608

Төслийн байршил: Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн "Шохой цагаан булаг" гэдэг газарт, Улаанбаатар хотоос зүүн хойш 90 км зайтай.

Газарзүйн солбицол: 107° 39' 02" 47° 50' 13" 107° 39' 27" 47° 50' 13"
107° 39' 27" 47° 49' 57" 107° 39' 02" 47° 49' 57"

Дэд бүтэц: Тус орд газар байрлах Эрдэнэ сумын нутаг дэвсгэр зам харилцаа сул хөгжсөн. Гэхдээ шаардлага хангахуйц орон нутгийн шороон замуудтай. УБ-Чингис хот чиглэлийн улсын хэмжээний авто зам дайрч өнгөрөх бөгөөд эндээс уурхай хүртэл 18 км байдаг. Хөдөлгөөнт утсан харилцааг ашиглаж болно. Цахилгаан хангамжийг Эрдэнэ сумын өндөр хүчдэлийн шугамаас 35 кВт хүчин чадалтай дэд станц салаалан авч ашиглаж байна.

Хүчин чадал: Нийт 25 га талбайд олборлолт явуулна. Сард 3000 тн шохойн чулуу олборлох хүчин чадалтай.

Ажиллах хүч: Уурхайд нийт 10 хүн ажилладаг.

Ажиллах хугацаа: 2009 оноос эхлэн ажиллаж эхэлсэн ба эхний төлөвлөлтөөр 3 жил ашиглана гэж тооцсон бөгөөд 2018 онд нөөцийн үнэлгээг “Голдман Прожект”-ХХК шинэчлэн хийлгэсэн. Жилийн дулааны улиралд нийт 8 сар, нэг ээлжээр ажилладаг.

Үр ашиг: Тухайн уурхай нь харьяалагдах засаг захиргааны нэгжийн нийгэм, эдийн засагт орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, холбогдох татваруудыг төлөх, орон нутгаас хүнсний хэрэгцээгээ хангах зэргээр үр ашигтай ажиллаж байна.

Эцсийн бүтээгдэхүүн: Шохойн чулуу

“ШОХОЙ ЦАГААН БУЛАГ” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Шохой цагаан булаг” ХХК-ийн Төв аймгийн Эрдэнэ сумын 1-р багийн Зүүн уурхайн нутаг дэвсгэрт байрлах Цагаан булаг орд нь Улаанбаатар хотоос 70, Төв аймгаас 97, Налайх дүүргээс 36, Улаанбаатараас Багануур орох төв замаас 15 км зайтай оршдог бөгөөд зам харилцаа, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн бүсэд байрладаг.


“Шохойн цагаан булаг” ХХК нь Монгол улсын 2911001065 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Шохойт уул нэртэй MV-000919 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий 25 га талбайг 2007 оны 1 сарын 29-ны өдрийн АМГТХЭГ-ын даргын шийдвэрээр “Шохой цагаан булаг” ХХК -д 30 жилийн хугацаатайгаар эзэмшдэг.

Цагаан булаг ордын хайгуулын ажлыг 1975 онд Барилгын материалын экспедицээс хайгуулын ангийг томилж ерөнхий нөөцийг тооцоолсон байдаг. Орд нь БУ-ЗХ чиглэлд 30-40⁰ –аар сунаж тогтсон байна. Геологийн тогтцын хувьд шохойн чулууны биет нь босоо уналтай, биетийн зузаан нь дунджаар 27 метр, ордын хэмжээнд боломжтой С зэргийн 1474 мян.тн шохойн чулууны нөөц батлагдсан байна. Ордыг ил аргаар ашиглах бөгөөд уурхайн оновчлолоор 538 мян.тн шохойн чулуу уурхайн хүрээнд багтаж, уурхайн эцсийн хүрээ, тусгай зөвшөөрлийн талбай дотор 311 мян.тн шохойн чулуу, хаягдал, бохирдол тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц 314 мян.тн гэж тооцоолсон байна. Уурхайн жилийн хүчин чадал 50 мян.тн бөгөөд уурхай нь улирлын чанартай, нэг ээлжээр ажилладаг.



Олборлосон шохойн чулууг уурхайн аман дээрээс борлуулах бөгөөд охин компани болох “Налгар түшиг” ХХК өөрийн зардлаар 31.8 км тээвэрлэн Налайх дүүрэгт байрлах цементийн үйлдвэрт түүхий эдээр ашигладаг. Уурхай нь 10 орчим хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг.

Ордын байршил болон сансрын зураг



MV-000919 тоот тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбилцол

	Уртраг	Өргөрөг	Талбай
	107° 39' 3.45"	47° 50' 14.77"	25.7 га
	107° 39' 28.45"	47° 50' 14.77"	
	107° 39' 28.45"	47° 49' 58.77"	
	107° 39' 3.45"	47° 49' 58.77"	

Ордын төв цэг нь уртрагийн 107° 39' 6.49", өргөргийн 47° 50' 4.56" солбилцолд байрлана.

Техник хэрэгсэл:



Бүс нутгийн мэдээлэл, хүн ам, эдийн засгийн байдал


Дэд бүтэц: Төв аймаг нь Улаанбаатар хоттой хиллэдэг учир харилцаа холбоо, авто болон төмөр зам зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Төв аймгийн Эрдэнэ сум нь Зуунмод хотоос 97 км зайтай оршдог ба уг сумд сумын ИТХ, ЗДТГ, Цагдаагийн хэсэг, Хүн эмнэлэг, Хүүхдийн “Нарлаг” цэцэрлэг, Соёлын төв, ХААН банк, Монгол шуудан банк, Холбоо, Эрчим хүчний салбар, Шатахуун түгээх станц, Мал эмнэлэг, “Агрико-Эрдэнэ” сүүний үйлдвэр, “Баадад” ХХК, зэрэг байгууллага, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг.

Хүн ам: Төв аймаг нь одоогийн байдлаар 94460 орчим хүн амтай. Хүн амын 16 хувь нь аймгийн төв (Зуунмод), 84 хувь нь хөдөө амьдардаг. Төв аймгийн хүн ардын 99.8 хувь Монгол улсын иргэн, 98.2 хувь монгол үндэстэн, 94.2 хувь халх ястан байна.

Эрдэнэ сум нь төрийн байгуулалтын хувьд 5 багт хуваагддаг 3717 хүн амтай, 1116 өрхтэй. Буриад, Казак, Дөрвөд, Урианхай, Баяд, Дархад, Захчин, Торгууд зэрэг олон үндэстэн ястан оршин суудаг. Эрдэнэ сум нь Төв аймгийн 27 сум дотроос хамгийн том буюу 8000 км² газар нутагтай.

Технологийн дараалал

Шохойн чулууг ордоос олборлоод тээвэрлэх хүртэлх үйл ажиллагааг технологийн схемээр харуулав.



Үйлдвэрлэлийн технологийн ерөнхий схем

Тус уурхайгаас олборлосон шохойн чулууг “Налгар Түшиг” ХХК-ийн Налайх дүүрэг дэх цементийн үйлдвэрт шууд нийлүүлдэг. Шохойн чулууны ордыг ашиглах, олборлолт явуулах үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Олборлолтын явцад газрын хэвлийгээс гарган авсан хөрс болон чулуулгийг ухсан нүхийг эргүүлэн дарах, нөхөн сэргээхэд ашиглахаар байгаа тул үүнийг хог хаягдал хэмээн үзэх нөхцөлгүй. Мөн технологи ажиллагаанд ус ашиглахгүй учир технологийн шингэн хаягдал гэж байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ:

Газарзүйн бүсчлэл:

Газарзүйн байршлын хувьд Өмнөд Хэнтийн мужийн ойт хээр, умард хуурай хээрийн дэд мужид хамаарагдана. Хан Хэнтийн ТХГН-ийн хэсэг болох Горхи-Тэрэлжийн бүстэй шууд залгаа оршино. Байгалийн төрхийн хувьд Хэнтийн нурууны өмнөд салбар уулсын хэв шинжийг агуулсан уулын нугат хээр, уулын хээр, уулын ойн ландшафт зонхилно.

Цаг уур, уур амьсгал:

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, тэгш хэмийн хуваарилалттай, хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижилхэн, зун сэрүүн, өвөл хүйтэн чийглэг байдаг. Харьцангуй их хур тунадастай, чийглэг, сэрүүн, өвөл нь цасархаг, хавар нь хахир, хуурайвтар, намар нь сэрүүн, үе үе манан татна. Агаарын жилийн дундаж хэм $-4,2^{\circ}\text{C}$, хамгийн хүйтэн хэм $-36,7^{\circ}\text{C}$, хамгийн дулаан хэм $31,3^{\circ}\text{C}$, жилийн нийлбэр хур тунадас $387,1$ мм, хөрсний жилийн дундаж хэм $1,4$, салхины дундаж хурд $1,5$ м/с байна.

Усан сүлжээ:

Уурхайн талбайн баруун хойгуур 8 км зайд Туул гол урсан өнгөрдөг. Голын сүлжээний нягтшил $0,01$ км/км²-аас бага, нийлбэр урсац >5 мм, гүний урсац >5 мм, ууршилтын боломжит хэмжээ 1250 мм болно. Уурхайд ойр орших гүний худгийн усны түвшин $3-4$ м, ундарга $0,08-0,36$ л/сек, эрдэсжилт бага, цэнгэг устай.

Хөрс:

Төслийн талбай бүхэлдээ уулын хар шороон хөрстэй. Эвдрэлд нэлээд өртсөн, хөрсний үе давхаргууд нимгэн, гадаргаас эхлээд сайр чулуурхаг, сул тогтоцтой, карбонатын хуримтлал төдий илэрдэггүй, давхаргуудын хоорондох шилжилт бага байдаг. Үржил шим сайтай, бэлчээрт ашиглагдах боломжтой.

Ургамлан бүрхэвч:

Ургамлын аймгийн зүйлийн бүрдлийг тогтоох судалгааны дүнгээс үзвэл, 85 овгийн 389 төрөлд хамаарах 1229 зүйл гуурст ургамал ургадаг. Зонхилох овгийн тоонд нийлмэл цэцэгтэн, үетэн, буурцагтан, холтсон цэцэгтэн, тоонолжин цэцэгтэн, иршимбэтэн, сонгинотон, баширтан зэрэг нь хамаарах ба нийт ургамлын 58%-ийг эзэлнэ. Зонхилох төрлийн тоонд улалж 4,7%, ортууз 1,6%, шарилж 1,4%, тарна 1,4%, бургас 1,1%, навтуул 1%, сонгино 1%, хувилгана 0,9%, хунчир 0,8%, банздоо 0,7% байна. Эдгээр нь бүх зүйлийн 14,7% эзэлнэ.

Амьтны аймаг:

Түгээмэл тархалттай шувууд, жижиг мэрэгчид, чоно, үнэг, өмхий хүрэн тохиолдоно. Нийт 37 овгийн 149 зүйл шувуу бүртгэгдсэнээс 121 зүйл нь өндөглөж зусдаг. Дагуур зараа, дагуур огодой, тарвага, урт сүүлт зурам, үлийн цагаан оготоно, Монгол чичүүл, сибирийн алагдаага, хотны үен, бор туулай, орог зусаг зэрэг жижиг мэрэгчид уулын хажуу хээрт элбэг тааралдана.

Геологийн тогтоц:

Шохойн чулууны орд нь Цагаан булагийн хөндийгөөр хуваагдан хоорондоо 1,5-2 км зайтай баруун, зүүн хэсгээс тогтоно. Ашигт малтмал нь эгц босоо уналттай, хар саарал өнгийн жижиг, нарийн ширхэгтэй гантигжсан шохойн чулууны давхарга юм. Петрографийн бичиглэлээр шохойн чулуу нь жигд бус нарийн ширхэглэг структуртай, параллель-занарлаг текстуртай байна.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхай нь байгаль орчинд харьцангуй их сөрөг нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэлийн салбарын нэг бөгөөд байгалийн нөөц баялгийг ашиглах явцдаа байгаль орчны унаган төрх, байгалийн төлөв байдалд өөрчлөлт оруулан, бохирдол эвдрэлийг үүсгэхийн зэрэгцээ түлш, эрчим хүч, ус зэргийг их хэмжээгээр ашигладаг.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа		Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд эрэг	Бага эрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт										
Гадаргын урсцын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х		х	
Геологийн тогтцын өөрчлөлт	х				х		х			х

Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x	x				x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x	x				x
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x				x	x			x	
Бэлчээрийн байдал	x				x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ		x		x			x			x
Гадаргын усны чанар хэмжээ										
Агаарын бохирдол	x				x	x			x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө	x				x	x				x
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x			x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x			x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x		x	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x	x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	x				x		x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x		x			x
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		x	
7. Бусад нөлөөлөл										
Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x	x		
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах		x		x			x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал, зайлуулалт муугаас эвгүй үнэр гарч, шавж үржих	x			x		x				x
Дүн, 35	22	4	1	3	24	7	20	1	14	12

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 22 (63%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс, ургамал, амьтан, геологийн тогтоц, газрын гадарга, бэлчээр, байгалийн дүр төрхөд, орчны бохирдол зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх муу

талтай байна. Харин орон нутгийн нийгэм-эдийн засагт шууд эергээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл

Нийт нөлөөллийн 4 (11%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Гүний усны чанар, хэмжээ, хүн амын эрүүл мэндэд шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөхөөр байна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь урт хугацааны нөлөөлөлд (69%) хамаарагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатай.

Нөлөөллийн чиглэл

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлж болзошгүй нийт нөлөөллийн 20 (74%) нь буцалтгүй буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хэвэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнийг нөхөн сэргээхдээ аль болох анхны төрхөд нь дөхүүлэх эсвэл дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй. Харин нийгэм-эдийн засагт эерэг, буцалтгүй нөлөөллийн эрчмийг дээшлүүлэх тал дээр төсөл хэрэгжүүлэгч анхаарвал зохино.

Нөлөөллийн эрчим

Энэ төслийн хүчтэй сөрөг нөлөөлөлд ажиллагсдын эрүүл мэнд өртөж болзошгүй. Гэвч үүнийг бууруулах үүднээс ХАБЭА-н журмыг сайтар баримтална. Хөрс, ургамал, газрын гадарга, эрдэс түүхий эдийн нөөц, орчны бохирдол зэрэгт дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, харин орон нутгийн нийгэм-эдийн засагт эерэг (дунд зэргийн) нөлөөлөл үзүүлэхээр байна. Нийт 27 нөлөөллөөс 1 нь хүчтэй, 14 нь дунд зэрэг, 12 нь сул нөлөөлөл бөгөөд 17 нь сөрөг, 10 нь эерэг нөлөөлөл байна.

Байгаль экосистемийн өөрчлөлт

Ордыг ашиглах үйл ажиллагааны үр дагавар нь орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, ургамал, амьтад урт хугацаанд, буцалтгүйгээр, дундаас бага зэргийн эрчимтэйгээр шууд нөлөөлнө. Тухайлбал: олборлох үйл ажиллагааны болон тээвэрлэлтийн явцад хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулах нөлөө гарна. Мөн салхи ихтэй үед ордын овоолго, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэргээс шороо тоос босож, агаар орчныг бохирдуулах, ойр орчны хөрс, ургамал тоосонд дарагдах, дуу чимээ, хөл хөдөлгөөнөөс амьтны амьдрах орчин багасах нөлөөлөл гарч болно. Уурхайн технологи үйл ажиллагааны явцад масло, түлш зэрэг санамсаргүй асгарч, хөрс ургамалд нөлөөлөл үзүүлж болзошгүй. Ордын ашиглалтын хугацаанд хүний үйл ажиллагааны улмаас орон нутгийн иргэд, тэдгээрийн амьдрах хэв маяг, бэлчээр зэрэгт шууд болон шууд бус нөлөөлөл үүсэж болзошгүй. Хөрс элэгдэл эвдрэлд өртөж, дагтаршин ургамлан бүрхэвч хэсэг хугацаагаар устгагдаж, малын бэлчээр нутаг хумигдана. Гэхдээ төслийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны үр дүнд эдгээр нөлөөллийг нэлээд хэмжээгээр багасгах боломжтой.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт

Уг төсөл нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн төсөл учраас байгалийн баялаг нөөцийг ашиглахтай холбоотой нөлөөлөл ихтэй. Байгалийн нөөц багасах, дутуу ашиглах, сорчилж ашиглах зэрэг сөрөг нөлөөлөл гарна. Мөн газрын гадаргын нөөц болох бэлчээрт урт хугацаанд дунд эрчмээр шууд нөлөөлнө.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл

Төслийн орчинд ямар нэг түүх, соёлын болон археологи, палеонтологийн олдвор илрээгүй учраас сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин байгалийн өөрийн дүр төрхөд гоо үзэмжийн хувьд сөрөг нөлөөтэй.

Эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл

Уурхайг ашиглах нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хугацаанд орлого оруулж, төсөл хэрэгжих хугацаанд болон цаашид орон нутагт ажлын байр шинээр бий болох, өрхийн орлого нэмэгдэх, ажилгүйдэл буурах, үйлдвэрлэл-үйлчилгээ тэлэх зэргээр эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Бусад нөлөөлөл

Уурхайчдын суурин нь байгаль орчинд зохисгүй нөлөөлнө. Тухайлбал, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих, ариутгал муу, ариун цэврийн дэглэмийг сахиагүйгээс халдварт өвчин гарч болох учраас үүнээс сэргийлэх холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дээр дурдсан болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг уурхайн олборлолтын онцлогтой холбож боловсруулан мөрдөж ажиллаж байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчин хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тухайн аж ахуйн, нэгж байгууллага болон байгаль орчинд ээлтэй эерэг талаас нь боловсруулж шаардлагатай хөрөнгө мөнгө, зардлыг жил бүрийн төсөвт тусгах, ингэснээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цаашид саадгүй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдол, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх нөлөөллийн арга хэмжээг бууруулах талаар төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эдэлбэр газрын хөрсийг хамгаалах талаар

- Олборлох явцад экологийн сөрөг нөлөө бүхий хөрсний эвдрэл үүсэх бөгөөд олборлолтыг өргөтгөх тусам хөрсний эвдрэлийн хэмжээ улам эрчимжинэ. Олборлолтын ажлаас өнгөн хөрс, шимт хөрсний нимгэн үе давхарга хуулагдах бөгөөд уг давхрагын өнгөн хөрсийг хуулж шинээр эдэлбэр газарт олборлолт хийгээгүй тул өнгөн хөрс хөндөгдөөгүй болно.
- Мэргэжлийн байгууллагаар хөрсний мониторинг судалгаа хийлгэж, хөрсний дээж авч шинжлүүлсэн.


Хөрсний мониторинг судалгаа шинжилгээ

Манай компаний зүгээс Цаг уур, орчны шинжилгээний газар, БОХТөв лабороторит хүсэлт тавьсны дагуу уурхайн орчны хөрсөн дахь хор нөлөөллийг бууруулах зорилгоор уурхайн ажил явагдаж буй карьерын урд хэсгээс дээжлэлтийг хийж шинжлүүлэв. Тоосжилт ихэссэн үед тоосжилтыг усалгаат машинаар услах замаар багасгаж мөн тээвэрлэлтийн үед хөрсөнд эвдрэл үүсгэхгүй үүднээс олон зам гаргалгүй замын эвдрэлтэй хэсгүүдийг тэгшлэх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллав.

Баримталсан стандарт

-MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагчийн дээд хэмжээ тогтоох үндсэн стандартыг мөрдлөг болгов.

Лабораторийн шинжилгээ1: Хөрсний шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ № : 2022/ 472-473
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Шохой Цагаан булаг” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг, агаарын хэсгийн техникч
Дээжийн тоо, төрөл : 2, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо : 2022.09.08
Дээжийн тодорхойлолт : Төв аймаг –Эрдэнэ сум
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2022.09.09
Хуудасны тоо : 1/1
Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Ажилчдын кемп	<0.005	35.2	<0.005	<0.005	169.2	30.4	9.3	338.8
2	Карьер орчмоос	1.0	18.1	<0.005	<0.005	35.2	30.0	12.2	362.9
	MNS 5850:2019 / ЗДХ/	3	100	2	150	300	100	50	800

Шинжилгээ гүйцэтгэсэн : Д.Баярхулан
Хөрсний хэсгийн инженер
Хянаж баталгаажуулсан : Б.Даваасүрэн
Хөрсний хэсгийн инженер



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Дүгнэлт:

2022 оны байдлаар уурхай нь шохойн чулуу олборлох үндсэн үйл ажиллагаа болон хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэв. Хөрсний био ялзмаг болон хүнд металлын агууламжийн MNS 5850:2008 стандартын баримтлан харьцуулж үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа гэдэг нь дээрхи дүнгээс харагдаж байна.

Усны эх үүсвэрийг хамгаалах талаар


Усны эх үүсвэрийг хамгаалахын тулд мэргэжлийн байгууллагаар мониторинг судалгаа хийлгэж Эрдэнэ сумын засаг захиргааны тамгын газартай хамтран усны ашигласны гэрээг тодорхой хууль дүрмийн дагуу хийж гүйцэтгэн ажиллалаа. Мөн гүний худаг гаргасан хэсгийг тусгаарлаж хашаа хайсжуулав.

Шинжилгээ: Манай компанийн зүгээс Цаг уур, орчны шинжилгээний газар, БОХЗТөв лабороторит хүсэлт тавьсны дагуу уурхайн гар худгийн усны чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд шинжилгээ хийлгэв.

Баримталсан стандарт

- MNS ISO 11923:2001 Байгаль орчин.Усны чанар. Умбуур бодисыг шилэн суултуурт шүүлтүүрээр шүүж тогтоох
- MNS ISO 8467:1999 Усны чанар. Перманганатын заалтыг тодорхойлох арга
- MNS 4431-2005 Ундны ус. Нитрит тодорхойлох арга
- MNS ISO 7890-3:2001 Усны чанар. Нитрат тодорхойлох
- MNS ISO 6878:2001 Байгаль орчин. Усны чанар. Аммоны молибдат ашиглан фосфор тодорхойлох спекрометрийн арга
- MNS 6272:2011 Усны чанар.Унды усанд фтор, ион тодорхойлох арга
- MNS 4430:2005 Ундны ус. Төмрийн агуулгыг тодорхойлох арга.

Лабораторийн шинжилгээ-2: Усны сорилтын дүн



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/ Ц-147
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Шохой Цагаан Булаг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.09.08
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970
Шинжилсэн огноо	: 2022.09.13-2022.10.03
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	pH	EC µS/cm	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃ мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
Төв аймаг Эрдэнэ сум Гүний худаг	8.54	307	24.9	17.7	55.5	8.6	4.5	161	272	3.48
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер

Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Тайлбар: Ж/Б- жинлэгдэгч бодис, ПИЧ- Перманганатын исэлдэх чанар, илр-илрээгүй
Химийн шинжилгээг дараах стандарт баримтлан хийлгэв.

-MNS ISO 10523:2001 Байгаль орчин. Усны чанар. Усны PH-г тодорхойлох

- MNS ISO 7888:1999 Усны цахилгаан дамжуулах чанар тодорхойлох
 - MNS 6271:2011 Усны чанар. Ундны усны сульфат ион тодорхойлох арга
 - MNS 4424:2005 Ундны ус. Хлоридын агуулга тодорхойлох
 - MNS ISO 6059:2001 Кальци ба магнийн нийт агуулгыг тодорхойлох
- Лабораторийн шинжилгээ-3: Усны сорилтын дүн



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/ Ц-147
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Шохой Цагаан Булаг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.09.08
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 6836:2020, MNS 6833:2020 MNS ISO 7150-1:2006, MNS 6779:2019 MNS 6834:2020, MNS ISO 6878:2001 MNS 4430:2005, MNS 6272: 2011
Шинжилсэн огноо	: 2022.09.13-2022.10.03
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мгN/л	NO ₂ мгN/л	NO ₃ мгN/л	PO ₄ мгP/л	Fe мг/л	F мг/л
Төв аймаг Эрдэнэ сум Гүний худаг	4.6	1.8	илр	0.006	50.9	0.002	0.04	0.01
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/б-Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, ИЛР-Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Тайлбар: ЕС- цахилгаан дамжуулах чанар, Хат- Хатуулаг, Эрд- Эрдэсжилт

Дүгнэлт: Шохойн чулууны уурхайн ундны усны хэрэгцээнд хэрэглэж буй гар худгийн ус нь химийн үзүүлэлтээр Монгол улсын “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS 900:2005 стандартын шаардлага хангаж байгаа нь дээрхи үр дүнгээс харагдаж байна.

Агаарыг бохирдуулахаас сэргийлэх талаар

- Хөрс хуулах болон хөрсний нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх үед мөн өөрөө явагч уулын техник, автомашины хөдөлгөөнөөс үүсэж болох агаарын тоосжилтоос урьдчилан сэргийлэхийн тулд хуурай, салхины хурд ихтэй үед үйлдвэрлэлийн талбай, замыг услан чийгшүүлж ажиллаж байгаа
- Агаарын чанарын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн

Агаарын чанар

Орчны агаарын хэвийн болон өөрчлөгдсөн төлөв байдал

- Гадаад орчны агаар задгай орчин дахь агаарын төлөв байдал
- Дотоод орчны агаар гадаад орчноос байгууламж, хийцээр тусгаарлагдсан агаарын төлөв байдал

Агаарын чанарын индекс (АЧИ) хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн агаарын чанарын үнэлгээ

- Хүлцэх агууламж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ
- Зөвшөөрөгдөх түвшин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ

Орчны агаарын чанарын шинжилгээ

Орчны агаарын чанарын үзүүлэлтийг дараах стандартын дагуу хэмжин, шинжилнэ.


- MNS 4048:1988, Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга;
- MNS 5365:2004, Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга;
- Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 зэрэг стандарт түүнд заадсан аргуудыг үндэслэн тооцоолсон.

Агаарын чанарын судалгаа

Төслийн талбайд одоогийн байдлаар хөрс хуулалт болон олборлолтын ажил хийгдэж байна. Үүнтэй холбоотой дуу чимээ үүсэх болон, тээврийн хөдөлгөөнтэй холбоотой тоосжилт тодорхой хэмжээгээр үүсч, агаарын чанарт нөлөөлж байна. Иймд уурхайн үйл ажиллагаанаас болон карьерын дотор ба гадна агаарын чанарт нөлөөллийн 2 цэгт тодорхойлж, Монгол улсын агаарын чанарын MNS 4585:2007 стандартын үзүүлэлттэй харьцуулж, агаарын чанарын индексээр илэрхийлэхийг зорьлоо.

Агаарын чанарын судалгааг тоос хэмжигч Dusttrack TSI, дуу шуугиан хэмжигч smart sensor R844 зэрэг багажуудаар хэмжилт, судалгааг хийлээ.

Лабораторийн шинжилгээ-4: Агаарын сорьцын шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/A-277
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Шохой Цагаан булаг” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.9.08
Дээжийн тодорхойлолт	: Налайх дүүрэг 3-р хороо тоосгоны үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.9.27
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Үйлдвэр буюу тоног төхөөрөмж	IX/08	12:05	0.018	0.025	0.080	60
2	Ажилчдын кемп	IX/08	13:40	0.021	0.027	0.085	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Байгаль орчны шинжилгээний инженер

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Дүгнэлт: Уурхайн агаарын чанарыг шинжлэхдээ карьеар дотор буюу гадна талбайд үндсэн 2 цэгт үзүүлэлтүүдийг хэмжихэд PM10 буюу том ширхэгт тоосонцорын агаарын чанарын индекс нь 0,100-аас бага буюу агаарын чанар стандартын шаардлага хангаж байна гэж үзэж байна. Мөн карьеар дотор дуу чимээ их байгаа нь дээрхи сорилтоос харагдаж байна.

Бусад

- Байгалийн унаган төрхийг алдагдуулахгүй байх үүднээс нөхөн сэргээлтийн ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу биелүүлсэн.
- Уурхайн тосгоноос сумын төв хүртэл тогтоогдсон нэг замаар зорчих боломж бүрдүүлэх, уурхайн эдэлбэрт зам, гарам зэргийг байнгын арчилж тордож байгаа.
- Ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний элэгдэл, усны горим, нөөцийн байдалд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хяналт шинжилгээ хийлгэсэн.
- Барилгын тоног төхөөрөмж, материал, контейнер зэрэг жин, овор ихтэй зүйлүүдийг нэг газраас нөгөө хэсэгт олон дахин чирж хөрс, ургамлаа сүйтгэхгүй байхаар урьдаас байрлалыг нь зөв сонгож төлөвлөн гүйцэтгэв.
- Автомашины зогсоолыг тохижуулахдаа тохиолдлоор бензин, тос гоожих, асгарах нөхцөлд доош хөрсөнд нэвчихээс хамгаалсан хаалт хийж, хатуу хучилт хийв.
- Барилгын материалыг түр хураах талбайг зөв сонгож байрлуулж ажиллав.
- Байгуулалтын ажлаас гарсан хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд тээвэрлэн зайлуулж хог хаягдлын гэрээний дагуу ажиллалаа
- Барилгад хэрэглэгдэх асгарах, гоожих бодисыг салхи, нар борооноос хамгаалсан тусгай байгууламжид хадгалж байв
- Барилга байгууламж барих үед болон цаашид ашиглах бие засах газрыг байгаль орчинд хор хөнөөлгүй байдлаар зохицуулав
- Хөдөлмөр хамгааллын тусгай дүрмийн дагуу ажиллалаа.
- Зам жим олширч элэгдэл эвдрэл ихсэх гэх мэтийг анхааралдаа авч ажиллав

Нөхөн сэргээх, байгаль орчин хамгаалах талаар хийсэн ажил

Шохой цагаан булгийн уурхайн ашиглалтын үйл ажиллагааны явцад уулын энгэр хажуугийн чулуурхаг бага зузаантай үржил шимт хөрсний үеийг тусад нь ангилан ялгаж зөөж овоолох ажил хийгдсэн. Энэ ажил нь шохойн чулууг олборлолтын ажлын мөчлөгтэй зэрэгцэн хийгдэх учир нэмэлт техник шаардагдахгүй, өөрөөр хэлбэл олборлолтын ажлын зардлаар хийгдсэн. Хуулах сул чулуулаг хөрсийг суларсан орон зайд дотор овоолго хийх замаар эргүүлэн дарах ба ухагдсан талбайг налуулах, тэгшлэх замаар өнгөн хөрсөөр хучиж техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна.

Шохойн чулуу тээвэрлэлт байнга явагдахгүй тул орон нутгаар өнгөрөх авто замыг олон салаалахгүй байх зарим хэсэгт замын хашилт барих, шаардлагатай үед усалгаа арчилгааг хийх ба ачигдсан чулууг тээвэрлэлтийн явцад салхинд хийсэж орчныг бохирдуулах магадлалтай тул хучих зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллав.

Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт хүснэгт-4

№	Хийх ажил	Хугацаа	Зардал мян.төг
1	Хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт тээвэрлэж зайлуулсан.	2022	800.0
2	Эрдэнэ сумын төвийн хогийн цэгт улиралд нэг удаагийн давтамжтайгаар хур хог хаягдалыг цэгцэлж нэг цэгт төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.	2022	Дотоод зардал
3	Гал түймрээс сэргийлэх арга хэмжээ авах, галын хэрэгслээр хангасан.	2022	-
4	Эрдэнэ сумын Өгөөмөр 1-р багийн хогийн цэгийг нэг цэгт төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.	2020	525.0
5	Ажилчдад байгаль орчны талаарх сургалт зохион байгуулав.	2020	Дотоод зардал
6	Эрсдэлийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд сургалт жилд 1 удаа зохион байгуулсан.	2020	Дотоод зардал
Дүн			1.325,0

1. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг “Шохойт Уул” гэдэг газар “Шохойн цагаан булаг” ХХК-ны шохойн чулууны орд газрыг эзэмших MV-0919А тоот тусгай зөвшөөрөлтэй газар түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй. Иймд төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл, эртний амьтан ургамлын үлдэгдэл илэрвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны анхдагч нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Палентологийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

Шохойн чулууны ордыг ашиглах, олборлолт явуулах үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Олборлолтын явцад газрын хэвлийгээс гаргасан хөрс болон чулуулгийг эргүүлэн ухсан нүхийг дарах, нөхөн сэргээхэд ашиглах тул үүнийг хог хаягдал хэмээн үзэхгүй. Мөн технологийн ажиллагаанд ус ашиглахдаа газрын хөрсөнд нөлөө үзүүлэхгүй учир технологийн шингэн хаягдалд тооцохгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүснэ. Хэлбэрээр нь:

1. Хатуу
2. Шингэн
3. Хийн гэж ангилна.

2.1. Ахуйн хатуу хог хаягдал:

Тус уурхайгаас гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байсан. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сан баглаа боодол эзэлнэ. Уурхайн үйл ажиллагаанаас доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарав. Үүнд:

- Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- Бие засах газрын хаягдал
- Ундааны сав, лааз
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Хог хаягдлыг зайлуулахдаа “Хог хаягдлын тухай ” Монгол улсын хуульд заасны дагуу Эрдэнэ сумын ТҮК-тай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Хүснэгт-5: Хатуу хог хаягдалын тооцооны хүснэгт

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хатуу хог хаягдлын хэмжээ					
Хоногт, кг	Сард, кг	Жилд, кг	Сард тээвэрлэх хуваарь	Жилд тээвэрлэх Хуваарь	Тээвэрлэлтийн нийт зардал мян. Төг
6.3	189.0	1512.0	1	8	400,0

2.2. Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал

Шохойн чулууны ордод олборлолт явуулах үйл ажиллагаанаас гарах технологийн хатуу хаягдал нь уурхайн нээлт ба гантиг чулуу олборлолтын явцад суллагдах сул чулуулаг болно. Энэ төрлийн хаягдлын хэмжээ нь ойролцоогоор тухайн жилийн олборлолтоос хамаарч янз бүр байх ба нийт олборлосон чулуулгийн 90% ашиглах боломжит түүхий эд байна гэж үзвэл 10% уулын чулуулаг үлдэнэ. Үүнийг тус уурхайн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглахаар отваль үүсгэж ажиллав.

2.3. Шингэн хог хаягдал:

Ахуйн шингэн хаягдал:

Технологийн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарахгүй. Унд ахуйн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарав. Унд ахуйн үйл ажиллагаанаас ялгарах шингэн хаягдлын хэмжээг тооцохдоо нийт хэрэглээний 80 % гэж үзэв. Шингэн хаягдлын хэмжээ 1 хоногт 0,2 м³, 1 сард 6 м³, 1 жилд 48 м³ байна.

Хүснэгт-6: Шингэн хог хаягдлын жилийн нэгдсэн тооцоо

Төслийн үйл ажиллагааны явцад гарах шингэн хог хаягдлын хэмжээ					
Хоногт, м ³	Сард, м ³	Жилд, м ³	Сард тээвэрлэх хуваарь	Жилд тээвэрлэх Хуваарь	Тээвэрлэлтийн нийт зардал мян. Төг
0,2	6	48	1	5	400,0

Жич: Тусгайлан гаргасан графикийн дагуу тухайн бүр нь тээвэрлэн хог хаягдлыг зайлуулав. Хог хаягдлыг зайлуулахдаа “Хог хаягдлын тухай ” Монгол улсын хуульд заасны дагуу Эрдэнэ сумын ТҮК-тай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэв. 2022 оны 5-р сарын байдлаар шингэн хог хаягдал соруулж, тээвэрлэн зөвшөөрөгдсөн цэгт зайлуулахад нэг удаагийн явалт нь 80,0 мян.төг байна. Нэг удаагийн гүйцэтгэлээр 10м³ хүртэл тээвэрлэв.

3. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах зохион байгуулалт, төлөвлөлт болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг “Шохой цагаан булаг” ХХК бүрэн хариуцна. БОХТ, ОХШХ-ийг жил бүр хийж гүйцэтгэн БОНХАЖЯ-аар баталгаажуулна. БОХТ-нд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх тусгай график гарган ажиллахын зэрэгцээ төлөвлөгөөний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллав.

- Мэргэжлийн байгууллагаар ус, агаар, хөрс, зэрэг хүчин зүйлсийн байгаль орчны мониторинг судалгааг хийлгэсэн.
- Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хууль, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр", "Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм", "Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллав.
- Нарийвчилсан үнэлгээний шатанд боловсруулсан Гантиг чулууны ордын орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг цаг тухай бүрд нь тогтмол биелүүлж ажиллалаа.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах хэмжээний зардлыг зарцуулсан байна.

БОХТ, ОХШХ-н үйл ажиллагаанд зарцуулсан зардал хүснэгт-7.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	250.0
2	Газрын гадарга, хөрсөн орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ	250.0
3	Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	250.0
4	Ургамлан нөмрөгийн мониторинг судалгаа	-
5	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт 2га талбайд мод тариалав	10,000.0
6	Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	1,325.0
Бүгд		12,075.0

4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

“Шохой цагаан булаг” ХХК-ийн Шохойн чулуу олборлолтын ажлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, үуурхайн бүсийн болон түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн судалгаа явуулсан. Уурхайн орчимд явуулсан орчны хяналтын мониторингийн ажиллагааг харуулав. Үүнд:

1. Агаар орчны чанар

Төслийн талбайд өнөөгийн байдлаар гантиг чулуу олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Тус үйлдвэрийн бүсэд үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа, болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор тоосжилт, дуу чимээ ихээхэн хэмжээтэй үүсэж, агаарын чанарт нөлөөлж байна. Иймд тус уурхайн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөллийн хэмжээг 4 цэгт тодорхойлж, Монгол улсын агаарын чанарын MNS 4585:2007 стандартын үзүүлэлтүүдтэй харьцуулж, агаарын чанарын индексээр илэрхийлэхийг зорьсон.

Агаарын чанарын судалгааг тоос хэмжигч Dusttrack TSI, дуу шуугиан хэмжигч smart sensor R 844 зэрэг багажуудаар хэмжилт, судалгааг хийлээ. Төслийн талбайн хими, физик нөлөөллийг хэмжиж, агаарын чанарын индексээр тооцож дараах хүснэгтээр илэрхийлэв.

Хүснэгт-8: Төслийн талбайн тоос болон дуу шуугианы үзүүлэлтүүд

№	Хэмжилтийн цэгийн нэр	Хэмжилтийн цэгийн байршил	Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа /минут/	Хэмжих нэгж	Стандарт	Хэмжилт	Агаарын чанарын индексийн тоон үзүүлэлт	Агаарын чанар болон өнгөний тэмдэглэгээ
1	Уурхайн ажилчдын байрны үүдэнд	47°49'55.7" 107°38'45.1"	Химийн нөлөөлөл						
			Тоос (Нийт жинлэгдэгч бодис)	15	мкг/м ³	500	250	50	Маш сайн
			Том ширхэглэгт тоосонцор (PM 10)	15	мкг/м ³	100	25	25	Маш сайн
			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5)	15	мкг/м ³	50	25.3	50.6	Маш сайн
			Физикийн нөлөөлөл						
Дуу шуугиан – Өдрийн цаг буюу 07-23 цагийн дундаж	15	дБА	60	54.1	90.2	Сайн			
2	Уурхайн овоолгын хойд талд	47°50'1.2' 107°38'56.68'	Химийн нөлөөлөл						
			Тоос (Нийт жинлэгдэгч бодис)	15	мкг/м ³	500	80	16	Маш сайн
			Том ширхэглэгт тоосонцор (PM 10)	15	мкг/м ³	100	12	12	Маш сайн
			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5)	15	мкг/м ³	50	12	24	Маш сайн
			Физикийн нөлөөлөл						
Дуу шуугиан – Өдрийн цаг буюу 07-23 цагийн дундаж	15	дБА	60	61.7	102.75	Дунд			
3	Уурхайн овоолго дээр дотоод замын хажууд	47°49'59.9" 107°39'1.3'	Физикийн нөлөөлөл						
			Тоос (Нийт жинлэгдэгч бодис)	15	мкг/м ³	500	1247.5	249.5	Маш муу
			Том ширхэглэгт тоосонцор (PM 10)	15	мкг/м ³	100	293.7	293.7	Маш муу
			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5)	15	мкг/м ³	50	69	138	Муу
			Химийн нөлөөлөл						
Дуу шуугиан –	15	дБА	60	77.4	129	Дунд			

			Өдрийн цаг буюу 07-23 цагийн дундаж						
4	Уурхайн ухаш дотор	47°50'2.78" 107°39'4.54'	Физикийн нөлөөлөл						
			Тоос (Нийт жинлэгдэгч бодис)	15	мкг/м ³	500		167.5	Муу
			Том ширхэглэгт тоосонцор (PM 10)	15	мкг/м ³	100	106	185	Муу
			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5)	15	мкг/м ³	50	90.75	181.5	Муу
			Химийн нөлөөлөл						
			Дуу шуугиан – Өдрийн цаг буюу 07-23 цагийн дундаж	15	дБа	60	81.55	135.9	Дунд


Тайлбар: Тус уурхайн ажилчдын байрны үүдэнд дуу шуугиан болон, нийт тоос, тоосонцор PM2.5, PM10 гэсэн үзүүлэлтийг хэмжихэд тоос тоосонцорын бохирдолгүй, харин дуу чимээ туршилтын хөрөөдөлт, тээврийн хэрэгслийн нөлөөгөөр бага зэрэг үүсэж байгаа боловч энэ 1-2 секундэд тархаж үгүй болж байна. Хэмжилтийн утгыг агаарын чанарын стандарттай харьцуулж, агаарын чанарын индексээр илэрхийлэхэд **сайн** гэсэн үзүүлэлттэй байна. 2-р цэг буюу уурхайн овоолгын хойд талд хийсэн хэмжилтээр агаарын чанар маш сайн гэсэн үзүүлэлттэй гарч байна. Гэвч дуу чимээ хувьд дунд гэсэн үзүүлэлттэй гарч байгаа нь хэмжилтийн хамгийн их утга хамгийн бага утгын зөрүү хэлбэлзэл ихтэй байсан холбоотой юм. Энэ цэгт дуу чимээний хамгийн их утга тээврийн хэрэгсэл овоолго чулууг асгах үед чулуу асгарах, овоолгын уруу өнхрөх, тээврийн хэрэгслийн моторын эргэлт нэмэгдэх зэргээс шууд хамаарч 85 дБа хүрч, хамгийн бага утга нь үүссэн дуу чимээ 1-2 секундний дараа агаарт тархан замхарсны дараа 38.2 дБа болж буурч байна.

Хэмжилтийн 3 цэгт агаарын чанар маш муу, муу гэсэн үзүүлэлттэй гарч байна. Хэмжилтийн 4 цэгт буюу уурхайн ухаш дотор хийсэн хэмжилтээр агаарын маш муу, аюултай гэсэн үзүүлэлттэй байна. Энэ хэмжилтээс үзэхэд 3,4-р цэгүүдэд агаар их тоосжилттой, мөн дуу чимээ ихтэй байна гэж үзэж болохоор байна. Энэ 2 цэг нь тус уурхайн агаар чанар болоод түүний үзүүлэлтүүд болох тоос, тоосонцор PM10, PM2.5 зэргийн бохирдлыг голомт болж байна. Эх үүсвэрээр нь авч үзвэл, автотехникийн хөдөлгүүрийн дуу чимээ, мөн түүний хөдөлгөөн, чулуулгийг асгах, буулгах, зөөх тээвэрлэх, ачих, тэсэлгээ хийх зэрэг байна.

Дээрх хэмжилтийн 4 цэгт бороо орсон хөрсний болон агаарын чийг хангалттай их байсан тул тоосжилт дарах дарах ажиллагаа хийгдээгүй байсан.

Агаарын чанарын индекс 100 ба түүнээс бага байвал агаарын чанар стандартын шаардлага хангаж байна, 101-ээс их байвал агаарын чанар стандартын шаардлага хангахгүй байна гэж үзнэ. Дээрх хүснэгтээс харахад тус талбайн орчимд агаарын чанарын физик нөлөөлөл болох дуу шуугиан болон химийн нөлөөлөл буюу тоос, тоосонцрын нөлөөлөл ихтэй байна.

Сум болон багийн төвлөрсөн хог хаягдалын цэгт улиралд нэг удаагийн давтамжтайгаар утгуурт ачигчаар тарсан хог хаягдалыг овоолж төвлөрсөн цэгт бөөгнүүлэх ажлыг гүйцэтгэв. Мөн хог хаягдалын цэгрүү орох зам талбайг түрж тэгшлэв.



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зарцуулсан ажлын нийт зардал:

ОХШХ хүснэгт-9

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Жилд	Нийт зардал мян.төгрөг
1	Агаарын шинжилгээ хийлгэх	1 удаа	250.0
2	Усны шинжилгээ хийлгэх	1 удаа	250.0
3	Хөрсний шинжилгээ хийлгэх	1 удаа	250.0
4	Ургамлан нөмрөг	1 удаа	0
5	Амьтны аймаг	1 удаа	0
Дүн			750.0

5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнасан хуваарь

№	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид ба оролцогч талууд	Тайлагнах хугацаа
1	Тухайн орон нутгийн ИТХ	2022 оны 4-р улиралд
2	Орон нутгийн засаг дарга	2022 оны 4-р улиралд
3	Нөлөөллийн бүс дэх оршин суугчдад хэвлэмэл хэлбэрээр хүргэх	2022 оны 4-р улиралд
4	БОАЖЯ болон орон нутгийн БО – ы мэргэжилтэн	2022 оны 4-р улиралд

ДҮГНЭЛТ

“Шохой цагаан булаг”-ХХКомпани нь 2022 оны БОМТ-г биелүүлсэн бөгөөд ОХШХ-ийн үр дүнгээс үзэхэд агаар, усан орчин, амьтанд сөрөг нөлөөгүй, хөрс, ургамлан орчинд олборлолтын явцад бага зэргийн сөрөг нөлөөтэй байна. Цаашид БОМТ болон БОМТ-ний биелэлтийг хууль журмын дагуу улам сайжруулан байгаль орчинд хор хөнөөл аль болох бага аргаар дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлтийг хийн ажиллана. Бид 2022 оны дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ, Жигд тэмүүлэл ХХК-тай хамтран Эрдэнэ сумын 1-Өгөөмөр 1-р багийн нутагт 4 га газар мод тариалах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хавсралтаар :

- Нийгмийн хариуцлагын гэрээ
 - Ус ашиглуулах дүгнэлт
 - Усны гэрээ
 - Хог хаягдалын гэрээ
 - Сум болон багийн төвийн хог түрэх ажиллагаа
 - Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн гэрээ
- Дээрхи бичиг баримтыг хавсаргав.

Ус ашиглуулах дүгнэлт



**ТӨВ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

41111, Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273290, Факс: 70272457
Цахим шуудан: boajg_tuv@gmail.com
Цахим хаяг: www.baigali.to.gov.mn

2022.08.08 № 07/261
танай _____-ны № _____-т

“ШОХОЙ ЦАГААН БУЛАГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.САРУУЛ ТАНАА

“Шохой цагаан булаг” ХХК-д ус
ашиглуулах дүгнэлт хүргүүлэх тухай

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Цагаан булгийн шохойн чулууны ордыг ил аргаар олборлох төслийн холбогдох материалыг судлан үзээд Монгол улсын “Усны тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн 2022 оны үйл ажиллагаанд усны нөөц ашиглуулах тухай дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

1м³ усны нөөцийн төлбөрийг 1510 төгрөгөөр тооцон аймгийн төсөвт (Төв аймгийн Татварын хэлтэсийн “Төв аймаг төрийн сан банк” дахь 100140000944 тоот дансанд), БОАЖ-ийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/376 тоот тушаалаар багтагдсан ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс 50000 төгрөгийг Төв аймаг Төрийн сан банкинд дахь /Тө.БОАЖГ н.с/ 100140013402 тоот дансанд тус тус төлөх нь зүйтэй.

Сумын Засаг даргатай 2022 онд ус ашиглах гэрээ байгуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгүүлэх, “Усны тухай” хуулийн 30 дугаар зүйл дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчдад тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой мэдээ тайланг дүгнэлтэд заасан хугацаанд ирүүлэх, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллах, ус ашиглуулах тухай дүгнэлтээр өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэн ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 2 хуудастай.

Хувийг: Эрдэнэ сумын Засаг даргад

ДАРГА



Ж.ДАШ-ЯЙЧИЛ

4122020205

**ТӨВ АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗАР УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

Дугаар 22/54

2022.08.08

Зуунмод

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар
“ШОХОЙ ЦАГААН БУЛАГ” ХХК, Гүйцэтгэх захирал Б.Саруул, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, “Их Найман Шарга” төвийн 5 давхарт, УБД:2911001065, РД:2025833, Утас:99062672, 88116981

2. Төслийн нэр, байршил: Төв аймаг, Эрдэнэ сумын нутаг, Шохой уул, Улаанбаатар хотоос зүүн зүгт 70 км, Налайх хотоос зүүн хойд зүгт 36 км-т байрладаг.

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Шохой цагаан булаг” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X,У/

Цагаан булгийн ордын тусгай зөвшөөрлийн дугаар MV-000919

Талбайн байршил

№	Уртраг	Өргөрөг	Талбай
1	107° 39' 3.45"	47° 50' 14.77"	25.7 га
2	107° 39' 28.45"	47° 50' 14.77"	
3	107° 39' 28.45"	47° 49' 58.77"	
4	107° 39' 3.45"	47° 49' 58.77"	

5. Төслийн зорилго: Цагаан булгийн шохойн чулууны ордыг Монгол улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт бүрэн хүлээлгэн өгөх, мөн “Налгар түшиг” цементийн үйлдвэрийг түүхий эдээр хангахад төслийн зорилго оршино.

6. Төслийн техник, технологи ажиллах горим, хүчин чадал: Уурхайн үйл ажиллагаа нь дулааны улиралд явагдах тул 365 хоногийн 210 өдөрт нь ажиллана. Уурхай нь хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цагаар ажиллана. Налайх дүүрэг дэх “Налгар түшиг” ХХК-ий цементийн үйлдвэрийн жилийн хэрэгцээ болох 50.0 мян.тн шохойн чулуу олборлохоор төслийн хүчин чадлыг тооцсон. Одоогоор уурхайд экскаватор, утгуурт ачигч, автосамосвал техникийг ашиглаж байна. Цаашид уурхайд шимт хөрс хуулалт, өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэх, овоолох гэсэн үндсэн процессууд явагдана. Уурхайд XCMG-DT14B бульдозер, өрмийн машин, QJ-15 маркын гар перфоратор болон туслах тоног төхөөрөмж болох 7 тн багтаамжтай түлшний машин, 2000 л багтаамжтай усны машин, уулын инженерүүдийн ажлын хэрэгцээнд зориулж Toyota Land cruiser 79 маркын суудлын машиныг авч ажиллуулахаар төлөвлөжээ.

7. Жилийн бүтээгдэхүүний хэмжээ: ТЭЗҮ-д жилийн хүчин чадлыг 50.0 мян.тн шохойн чулуу олборлохоор тусгасан бөгөөд, цаашид үйлдвэрлэлийн нөөц 7 жил ашиглахаар төлөвлөжээ.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/: Ундны усны эх үүсвэрийг Налайх дүүргээс зөөж хэрэглэж байна. Уурхайн техник, технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй бөгөөд зам талбайн тоосжилт дарах ажилд орон нутгийн худгаас хангахаар төлөвлөсөн.

9. Байгаль орчны үнэлгээ, нохиол:

Төсөлд БОНБНҮнэлгээг “Эко түшиг” ХХК-аар хийлгэсэн байна. БОНБНҮТайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг багасгах, арилгах зөвлөмж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажилласан тохиолдолд энэхүү төслийг хэрэгжүүлэх боломжтой юм. Байгаль хамгаалах төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлж, түүнд усны нөөцийг зүй

зохистой ашиглах, бохирдлоос хамгаалах ажлыг тусган хэрэгжилтийг дүгнэн ажиллаж, жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөг аймгийн БОАЖГ-т бүртгүүлж, төлөвлөгөөний тайланг ирүүлж байх.

10.Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцоход:

- Ажилчдын унд ахуйн хэрэгцээнд – $13\text{хүн} \times 30\text{л} \times 365\text{хоног} = 142,35\text{м}^3$
- Бүтээгдэхүүн тээвэрлэх замын тоосжилт дарахад - $6000\text{м}^2 \times 2\text{л} \times 20\text{удаа} = 240\text{м}^3$
- Уурхайн талбайн тоосжилт дарах – 200м^3
- Нийт усны хэрэглээ $142,35\text{м}^3 + 240\text{м}^3 + 200\text{м}^3 = 582,35\text{м}^3$

Хоногт ашиглах ус- $2,8\text{м}^3$

11.Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 заалтын дагуу унд ахуйн хэрэгцээнд жилд ашиглах $142,35\text{м}^3$ усыг төлбөрөөс чөлөөлнө.

Цагаан булгийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах газрын доорхи усны төлбөрийн хэмжээг Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох нигэлцүүр, 2013 оны 326-р тогтоолын 1-р хавсралтад заасан төлбөрийн хувь хэмжээг ашиглан тооцож, “Төсвийн тухай” хуулийн 23.6.5, 23.8.9-д заасны дагуу аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй.

1м^3 усны нөөцийн төлбөр $9440 \times 0,8 \times 0,20\% = 1510\text{төг}$

Усны төлбөр $440\text{м}^3 \times 1510\text{төг} = 664\,400\text{төг}$

12.Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- “Усны тухай” хуулийн 28.6, 28.11-д заасны дагуу ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Эрдэнэ сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч, ус ашиглах гэрээ байгуулж, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгүүлэх.
- “Усны тухай” хуулийн 30 дугаар зүйлийн дагуу ус ашиглагчдад тавигдах шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах.
- Байгууллагын жил бүрийн бизнес төлөвлөгөөнд үндэслэн усны хэрэглээг урьдчилан тооцуулж ус ашиглах дүгнэлтийг үйл ажиллагаа өндөрчлөх нэг сараас доошгүй хугацааны өмнө гаргуулж, бодит хэрэгцээг үнэн зөв тусгасан ус ашиглалтын тайланг 12 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх.

Ерөнхий дүгнэлт: БОНБНҮнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, зэргийг үндэслэн дээрхи төсөлд ус ашиглуулах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зөвлөмж, шаардлагуудыг бүрэн ханган ажиллах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН МЭРГЭЭЛЭЛТЭН

 Ж.ОЮУННАРАН

Ус ашиглах гэрээ

БАТЛАВ:
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧИЙН ИРГЭНЭБААТАР

“Шохой цагаан булаг” ХХК

/Эрдэнэ сум ЗДТГазар /

/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 08 сарын 09-ний өдөр

Дугаар 06

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д -д заасны дагуу Байгаль орчны сайдын 153 дугаар тушаалаар батлагдсан нормын дагуу төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба/ 2022 оны 08-р сарын 08-ний өдрийн 07/85 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн, Ус ашиглуулагчийг төлөөлж Эрдэнэ сумын БОХУБайцаагч албан тушаалтан Шархүү овогтой Гэрэлт-Од Ус ашиглагчийг төлөөлж 2911001065 улсын бүртгэл, 2025833 регистрийн дугаартай “Шохой цагаан булаг” ХХК-ны гүйцэтгэх захирал Б.Саруул нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Ахуйн

2.2. Ажилчдын унд ахуйд- 142.35м³

2.2.1. Бүтээгдэхүүн тээвэрлэх замын тоосжилт дарах – 240 м³

2.2.2. Уурхайн талбайн тоосжилт дарах- 200м³

2.2.3. Усны нийт хэрэглээ – 582.35 м³

Нийт – 582.35м³

2.2.4. эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.3.5. Усны чанар, найрлага

Гурав. Усны эх үүсвэрийн:

Байршил .Төв аймаг Эрдэнэ сум Өгөөмөрийн 1-р баг Зүүн Шохойн аманд байрлана.
Солбилцол: уртраг- өргөрөг- Нийт 25.7 – га

Барилга байгууламж
.....

Тоног төхөөрөмжийн нэр, марк

Хүчин чадал м гүн ундарга ,тогтсон түвшин --м

2.5. Хаягдал усны:

Хэмжээ

Стандартын шаардлага

Хаях цэгийн байршил

C,Y....., Z

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг

Органик бодис, кг

Эрдэс бодис, кг

Хүнд металл, кг

Аюултай бохирдуулах бодис, гр

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин

.....

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуурын: Гар худаг

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 664.400 төгрөг

Нэхэмжлэх үүсгэж дансанд төвлөрүүлэх

/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

2.11. **Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:**
/ус бохирдуулсны төлбөр/

Гурав. Талуудын эрх, үүрэг: Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад : 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:


БОХУБ Ш.Гэрэлт-Од

Харилцах утас: 99815599

Ус ашигчигийг төлөөлж:


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛГ Б.САРУУЛ

Харилцах 99062672

Хог хаягдалын гэрээ

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧИЙН ГЭРЭЭ



ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭСНИЙ ТӨЛБӨР ТӨЛӨХ ГЭРЭЭ

2022.08.09

№ 25

Эрдэнэ-Уул

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.4.2 дахь заалтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Байгаль Орчны Хяналтын Улсын Байцаагч **Ш.Гэрэлт-Од** хог үүсгэгчийг төлөөлж 2911001065 улсын бүртгэл, 2025833 регистрийн дугаар бүхий “Шохой цагаан булаг” ХХК-ны гүйцэтгэх захирал Б.Саруул нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 08 дугаар сарын 09- ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Хог үүсгэгчийн үүрэг:

1.1.Тогтоосон чиглэлийн дагуу хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх

1.2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааг ханган тээвэрлэх

1.3. Хог хаягдлын төлбөр хураамжийг сар бүр төлөх

Сумын ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу **хог хаягдлын төлбөр** / уул уурхайн зориулалтаар үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-ажиллаж байгаа сар тутам 100.000 төгрөг /

Хоёр. Захиалагчийн үүрэг:

2.1.Хог хаягдлын тогтоосон цэгийг хаягжуулан хязгаарлалтыг тогтоосон байх

2.2. Иргэн аж ахуйн нэгж байгууллага орчин газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах

Гэрээний хүчинтэй хугацаа:

А. Эхлэх: 2022 оны 01 дүгээр сарын 1-ний өдөр

Б. Дуусах: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Гурав. Гэрээ байгуулагч талууд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай 9 дүгээр зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

Гэрээ нь Засаг дарга баталсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

Гэрээний биелэлтийг талууд жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

- Аль нэг тал үүргээ биелүүлээгүй бол нэг талын санаачлагаар
- Гэрээ байгуулсан талын аль нэг нь татан буугдсан.

Гэрээний нөхцлийг биелүүлээгүй дутуу биелүүлсэн бол буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗЛТ-Г ТӨЛӨӨЛЖ
БОХУБ Ш.ГЭРЭЛТ-ОД
Утас: 99815599

ХАРИЛЦАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИВАЛ Б.САРУУЛ
Утас: 99002672

Нийгмийн хариуцлагын гэрээ /Гэрээг хавсаргав/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ № 08

Энэхүү гэрээг нэг талаас **ТӨВ АЙМАГ ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА АЮУШИЙН МӨНГӨНБАЯР** /цаашид “сумын Засаг дарга гэх/ нөгөө талаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, “**Шохой цагаан булаг**” **ХХК** цаашид “иргэн аж ахуйн нэгж” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож **2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр** Төв аймгийн Эрдэнэ суманд байгуулав.

НЭГ. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээ нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа /аж ахуйн нэгж, иргэнтэй/ дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах асуудлаар сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь

- 20 тн цемент 250 литр түлш сайн дурын сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж хэрэгжүүлэх

2.1.2. Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл, хөтөлбөр, бага хүүтэй зээлд хамруулах

2.1.3. Бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах, худалдан борлуулах, гадаад, дотоод түншлэлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

2.1.4. Бизнесийн орчныг дэмжсэн үйл ажиллагааг нэмэгдүүлж, үзэсгэлэн худалдаа, өдөрлөгийг зохион байгуулах

2.1.5. Улс аймгийн шагнал урамшуулалд тодорхойлж, үндэсний болон орон нутгийн арга хэмжээнүүдэд оролцуулах

2.1.6. Үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн салбарт тавигдах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт шаардлагыг хангуулахад анхаарч, хяналт тавьж ажиллах

2.1.7. Стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болоход нь зохион байгуулалтын арга хэмжээ авч гүйцэтгэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагад зуучлах

2.1.8. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах

2.1.9. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх

2.1.10. Зарлагдсан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах

ГУРАВ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Үйлдвэрлэл үйлчилгээний стандартыг бүрэн биелүүлж, шилдэг менежмент, маркетингийг нэвтрүүлж, үйл ажиллагаагаа тогтмолжуулах

3.1.2. Хэрэглэгчээ дээдэлж, үйлдвэрлэл, үйлчилгээний ая тухтай тохилог орчин нөхцөлийг бүрдүүлж, эрүүл ахуй, чанарын стандарт хангасан бүтээгдэхүүн үйлчилгээгээр үйлчлэх

3.1.3. Санхүү, татварын тайлан, статистикийн мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлэл, татвар хураамжаа цаг хугацаанд нь бүрэн барагдуулах

3.1.4. Сум орон нутгаас зохион байгуулж байгаа олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох

3.1.6. Үйл ажиллагаа явуулж байгаа орчин нөхцөлдөө үйлдвэрлэлийн осол гэмтэл, гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, тогтмол хяналт тавьж ажиллах

3.1.7 Аж ахуйн нэгж, байгууллагын байр, талбайг стандартын дагуу тохижуулж, зам талбай байгуулан, гэрэлтүүлэг, хаягжуулж, 20-с доошгүй мод тарьж орчноо зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

3.1.8. Хог хаягдлын зориулалтын сав байрлуулан, тогтоосон хугацаанд хогийн цэгт зайлуулах, хог хаягдлын хураамжийг сар бүр төлж хэвших

3.1.9. Стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болох

3.1.10. Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах

3.1.11. Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх

3.1.12. Хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох

3.1.13. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, суманд салбараар бүртгүүлсэн байна

3.1.14. Шаардлагатай тохиолдолд сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг тусалцаа үзүүлэх

ДӨРӨВ. Гэрээний хэрэгжилт

4.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлнэ.

4.2. Талууд гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлнэ.

ТАВ. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа

5.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ

5.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй нэг хэсэг байна.

5.3. Гэрээг хоёр хувь үйлдэнэ.

ГЭРЭЭГ ЗӨВШӨӨРЧ БАЙГУУЛСАН:

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

А.МӨНГӨНБАЯР
88840801



Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн гэрээ

БАТЛАВ:



**ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ 4 ГА ТАЛБАЙД
ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2022 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

№

Улаанбаатар хот

Эрдэнэ сумын нутагт 4 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээг нэг талаас “Захиалагч” талыг төлөөлж Шохой цагаан булаг ХХК-ийн захирал Ж.Батбаяр нөгөө талаас “Ажил гүйцэтгэгч” Жигд тэмүүлэл ХХК-ийн захирал Ж.Цэрмаа нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

Ажлын нэр: Эрдэнэ сумын нутагт 4 га талбайд ойжуулалт хийх

Ажил үйлчилгээний төлбөр: 10.000.000

Гэрээний хугацаа: 2022.08.31-10.31

1. Нийтлэг заалт

- 1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу, Эрдэнэ сумын нутагт 4 га талбайд ойжуулалт хийх ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн ажлын гүйцэтгэлийн талаар орон нутгийн ойжуулалт хүлээн авах комисст хүлээлгэн өгч акт авч захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд өгөх, нөгөө талаас захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү Гэрээ нь 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 2 сарын хугацаатай байна.
- 2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. Ажил үйлчилгээний төлбөр

- 3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын үйлчилгээний төлбөр нийт 10.000.000 (Арван сая төгрөг) төгрөг байна (Үүнд НӨАТ орсон болно).
- 3.2 Захиалагч нь гэрээт ажлын урьдчилгаа 60 хувь болох 6.000.000 (зургаан сая) төгрөгийг ажил гүйцэтгэгчийн Хаан банкны 5721513687 тоот дансанд гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор шилжүүлж гэрээг баталгаажуулна.
- 3.3 Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэвэл зохих нийт ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж Захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд Захиалагч ажлыг үр дүнг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор ажил үйлчилгээний үлдэгдэл төлбөр 40 хувь болох 4.000.000 (дөрвөн сая) төгрөгийг ажил гүйцэтгэгчийн Хаан банкны 5721513687 тоот дансанд шилжүүлнэ.

4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.2 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 4.4 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 4.5 Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардалаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах эрхтэй.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.3 Дараахь тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:
 - Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
 - Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
- 5.4 Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.
- 5.5 Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасаны дагуу шаардах эрхтэй.
- 5.6 Ажил үйлчилгээний даалгаварын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

6. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1 Талууд энэхүү гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.

- 6.2 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлэх журмыг баримтална.

7. Бусад заалт

- 7.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
7.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
7.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
7.4 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон асуудлаар 2 тал харилцан тохиролцож хууль, тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

8. Талууд

Захиалагч: **Б.Саруул**

Гарын үсэг: Б.Саруул

Утас: 99062672

Ажил гүйцэтгэгч: **Ж.Цэрмаа**

Гарын үсэг: Ж.Цэрмаа

Утас:

/Тамга тэмдэг/

/Тамга тэмдэг/